



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2020/1/СТА-ТӨҮГ

Баянхонгор 2020 он	Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 88089024 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Ж.Өсөхбаяр Утас: 99890393 Цахим хаяг: usuhuu83@yahoo.com Цахим хуудас: www.audit.mn
-----------------------	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар

1. Аудитын гэрчилгээ	3
2. Аудитын тайлан.....	5
2.1. Оршил	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	6
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	7
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	7
2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	7
2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.13. Шилэн дансны мэдээлэл	9
2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал.....	9
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	11
4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	11
4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	12
4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	13

1. Аудитын гэрчилгээ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

64101 Баянхонгор аймаг,
Баянхонгор сум, Номгон баг
Утас, факс 7044 2584
E-mail: bayankhongor@audit.gov.mn

Г БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ НИСЭХ^Г
БУУДЛЫН ДАРГА Ж.ГАНХҮЛЭГ
ТАНАА

2020.03.12 № 1/316

танай _____ -ны № _____ -г

Г Аудитын гэрчилгээ Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

• 005020266

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.МӨНХБАТ

D:\бичиг хэрэг 2020-Албан тоот А4\

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Ж.Ганхүлэг танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайланд аудит хийлээ.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 03 дугаар сарын 2-ноос 2020 оны 03 дугаар сарын 10-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 12-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ж.Өсөхбаяр хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын үйл ажиллагааны эрхэм зорилго нь "Нисэхийн аюулгүй байдлыг найдвартай ханган, агаарын тээврийн ая тух, түргэн шуурхай үйлчилгээг бий болгож, зорчигчдод соёлч боловсон үйлчлэх нь бидний эрхэм зорилго мөн".

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нисэхийн аюулгүй үйл ажиллагаа болон нисэхийн аюулгүй байдлыг хангаж, зорчигч тээврийн үйлчилгээг чанартай хүргэх
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт гараагүй байна.
 - Иргэний нисэхийн тухай хууль
 - Төсвийн тухай хууль
 - Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
 - Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
 - Шилэн дансны тухай хууль

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ИНЕГ-ын даргын А/901 тоот тушаалаар баталж мөрдүүлж байгаа ба Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд "Интер актив" ХХК-ийн "Veritech" программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг дунд гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 983945.8 мянган төгрөгөөс тооцон 19678.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 19678.9 мянган төгрөгөөр тооцсон нь байгууллагын нийт зардлыг суурь үзүүлэлт болгон сонгох нь зохимжтой гэж үзсэнтэй холбоотой юм.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 121630.2 мянган төгрөгөөр буюу 5.2 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	712.44	5,312.51	4,600.07
Дансны авлага	1,387.16	4,374.71	2,987.56
Бусад авлага	5,310.93	3,046.62	-2,264.31
Бараа материал	102,243.48	91,391.15	-10,852.33
Эргэлтийн хөрөнгийн дүн	109,654.01	104,124.99	-5,529.01
Үндсэн хөрөнгө	6,865,902.33	6,902,826.27	36,923.93
Хуримтлагдсан элэгдэл	4,630,193.42	4,783,218.51	153,025.09
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,235,708.92	2,119,607.76	-116,101.16
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,345,362.93	2,223,732.75	-121,630.17
Өр төлбөрийн нийт дүн	1,480.89	0	-1,480.89
Эздийн өмч	1,519,736.49	1,519,736.49	0.00
Хуримтлагдсан ашиг	824,145.55	703,996.27	-120,149.29
Эздийн өмчийн дүн	2,343,882.04	2,223,732.75	-120,149.29
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,345,362.93	2,223,732.75	-121,630.17

Бараа материалын дансны үлдэгдэл 10852.3 мянган төгрөгөөр буурсан нь аж ахуйн материал, сэлбэг хэрэгсэл, түлш шатахууны өмнөх оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд өмнөх онуудад худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн нь тайлант онд 37245.8 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй 5789.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 05 дугаар сарын 23-ны А-5/1435 тоот албан бичгийн дагуу 10184.8 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 2223732.7 мянган төгрөг болж 120149.3 мянган төгрөгөөр буурсан нь хуримтлагдсан үр дүн 120149.3 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Иргэний нисэхийн ерөнхий газраас Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын орлогын төлөвлөгөөг 4972.0 мянган төгрөгөөр, зардлын төлөвлөгөөг 788226.0 мянган төгрөгөөр баталсан байна.

2.11. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 11 эрсдэл тодорхойлж нийт 11 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 21910.5 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 331.2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 18531.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, 3046.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өгч 1.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар дараах 18862.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 331.2 мянган төгрөгийн зөрчилд акт тогтоож, 18531.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч 1.7 мянган төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулав. Үүнд:

1. Цалингийн зардлыг давтан тооцооллыг хийхэд улирлын чанартай ажил эрхэлдэг уурын зуухны галч, машинист 3 ажилтны даатгуулагчаас төлөх НДШ-д 331.2 мянган төгрөг төлсөн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.8 дахь " " Улирлын шинж чанартай Хуанлийн жилд 7 сараас доошгүй хугацаагаар улирлын чанартай ажил, үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг ажилтны нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан ажил олгогчийн төлөх шимтгэлийн хувь хэмжээгээр төлнө" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв.

2. Тайлант онд цалингийн зардлаас ажлаас чөлөөлөгдсөн 3 ажилтны шүүхэд хандсан нэхэмжлэлийн дагуу гаргасан шүүхийн шийдвэрийг үндэслэн 18531.0 мянган төгрөгийн нөхөн олговор, улсын тэмдэгтийн хураамжийг төсвөөс төлсөн байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн, "Эрх ба үүрэг", гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2 дахь заалтын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3. Татварын хэлтэст цалингаас төлсөн ХХОАТ-ын 1666.4 төгрөг илүү төлсөн ч мөнгөн гүйлгээн тайланд орлогоор бүртгэж авлагыг хаасан байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулав.

Аудитаар илэрсэн 3046.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.12. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

2.12.1. Нисэх буудлын дарга Н.Баярхүүгийн 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Б/05 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн уурын зуухны механикч Г.Цэдэнбалд Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00398 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 12,296,122 төгрөг, 2018 оны 07 дугаар сарын 23-ны өдрийн Б/35 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч Б.Хүрэлбаатарт Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 131/ШШ2019/00935 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 4,421,824 төгрөг, 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн Б/11 тоот тушаалаар ажлаас чөлөөлөгдсөн жолооч А.Болорчулуунд Баянхонгор аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 131/ШШ2018/00461 тоот шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт 1,727,381 төгрөг улсын тэмдэгтийн хураамжид 85,699 төгрөг нийт 18,531,026 төгрөгийг Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын төсвөөс олгосон байна. Энэхүү зөрчил нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ" гэсэн заалтыг зөрчсөн тул Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэсэн заалтыг үндэслэн Иргэний

нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанд албан шаардлага хүргүүлсэн тул хэрэгжилтийн талаар арга хэмжээ авсан эсэхийг тодруулж үзэх.

2.13. Шилэн дансны мэдээлэл

Баянхонгор аймаг дахь Нисэх буудал Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 132 мэдээллийг хугацаанд нь, 15 мэдээлэлд байршуулснаас хойш дахин засвар хийснээс хугацаа хоцроосон төлөвт орж, 2 мэдээллийг байршуулах хугацаа болоогүй байна.

Д/А	Хугацаа	Төрөл	Удаа	Хугацаанд оруулсан	Хугацаа хоцроосон	Хугацаа болоогүй
1	Бүтэн жил	11	11	7	2	2
2	Хагас жил	4	4	4		
3	Улирал бүр	1	4	2		
4	Сар бүр	3	36	33	3	
5	Тухай бүр	8	96	86	10	
	Нийт	27	151	132	15	2

2.14. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.15. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг НББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1 дахь заалтын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаа

1.1. **Илрүүлэлт:** Аж ахуйн нярав нь эргэлтийн хөрөнгийн тайланг сар гаргахгүй улирлаар гаргаж байгаа, онгоцны ТС-1 шатахууны тайланг мөнгөн дүнгээр илэрхийлэн гаргахгүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан "Аж ахуйн нэгжийн тайлан, тодруулга, бэлтгэх заавар"-ын 2.6 дахь "НББОУС 2 Бараа материал–д заасны дагуу бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь үнэлнэ. Бараа материалын цэвэр боломжит үнийг тайлант үе бүрийн эцэст тооцно" гэсэнтэй нийцэхгүй байна.

1.2. **Эрсдэл:** Аж ахуйн материалын тайланг тухай бүр гаргаагүй байх

- 1.3. **Өгсөн зөвлөмж:**
Нярав аж ахуйн материалын тайланг сар бүр мөнгөн дүнгээр илэрхийлж гаргаж, нягтлан бодогч баталгаажуулж байх
- 1.4. **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Цаашид алдааг давтан гаргахгүй зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.
2. **Балансын данстай холбоотой асуудал**
- 2.1 **Илрүүлэлт:** Тайлант онд гэрээт байгууллагуудын 4374.7 мянга, ажиллагсадтай холбоотой 3046.6 мянган төгрөгийн авлага бүртгэлтэй байгаа ба байгууллагуудын авлага нь 2020 оны 01 дүгээр сард барагдсан бол ажиллагсадтай холбоотой 3046.6 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж ажиллаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.
- 2.2. **Эрсдэл:** Авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй байх
- 2.3 **Өгсөн зөвлөмж:** Ажилчидтай холбоотой авлагыг барагдуулах талаар ажил зохион байгуулж авлагыг бүрэн барагдуулж хуулийг хэрэгжүүлж ажиллах.
- 2.4 **Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:** Аудитаар илэрсэн алдааг хүлээн зөвшөөрч байна, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	712,439.27	5,312,512.16
Дансны авлага	1,387,155.10	4,374,710.90
Бусад авлага	5,310,929.12	3,046,621.02
Бараа материал	102,243,484.62	91,391,150.85
Эргэлтийн хөрөнгийн дүн	109,654,008.11	104,124,994.93
Үндсэн хөрөнгө	1,204,748,916.98	1,088,647,758.32
Биет бус хөрөнгө	1,030,960,000.00	1,030,960,000.00
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,235,708,916.98	2,119,607,758.32
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,345,362,925.09	2,223,732,753.25
Татварын өр	221,885.10	0
Бусад богино хугацаат өр төлбөр	1,259,000.00	0
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,480,885.10	0
Өр төлбөрийн нийт дүн	1,480,885.10	0
Эздийн өмч	1,519,736,486.75	1,519,736,486.75
Өмч: - төрийн	1,030,960,000.00	1,030,960,000.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	488,776,486.75	488,776,486.75
Хуримтлагдсан ашиг	824,145,553.24	703,996,266.50
Эздийн өмчийн дүн	2,343,882,039.99	2,223,732,753.25
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,345,362,925.09	2,223,732,753.25

4.2 Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Борлуулалтын орлого	12,236,316.72	11,356,067.59
Буулт хөөрөлтийн орлого	1,637,790.00	4,339,317.74
Буудлын хураамж	0	730,840.00
Газрын техник үйлчилгээний орлого	3,440,789.00	5,988,210.80
Шатахуун тээвэрлэлтийн орлого	6,237,757.01	0
Үйл ажиллагааны бусад орлого	919,980.71	297,699.05
Боруулалтын орлогын дүн	12,236,316.72	11,356,067.59
Борлуулалтын өртөг	815,844,282.97	926,499,819.85
Бичиг хэрэг	5,039,426.88	5,189,409.49
Албан конторын зардал	847,260.00	2,501,607.57
Шатахуун	46,947,342.41	50,252,572.52
Үндсэн цалин	215,273,680.47	252,626,448.92
Илүү цаг	17,293,170.08	21,376,419.30
Амралтын мөнгө	32,830,338.63	39,492,284.27
Цалингийн бусад нэмэгдэл	95,498,518.91	118,469,428.09
Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн	360,895,708.09	431,964,580.58
Хоолны үнийн хөнгөлөлт	54,980,000.00	54,050,000.00
Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	53,225,598.48	66,422,744.83
Сэлбэг засвар-Барилга	7,483,959.72	24,371,031.04
Сэлбэг засвар-Автомашин	8,316,741.02	8,315,959.32
Сэлбэг засвар-Аэродром	10,235,517.81	10,248,316.40
Сэлбэг засвар -ТТ	18,444,244.11	12,359,336.36
Сэлбэг засвар	44,480,462.66	55,294,643.12
Цахилгаан	23,303,910.55	23,414,090.54
Дулаан	16,067,370.42	18,462,474.85
Холбооны зардал	5,874,087.73	6,535,345.57
Ашиглалтын зардлын дүн	45,245,368.70	48,411,910.96
Үндсэн хөрөнгийн элэгдэл	135,139,231.13	157,857,223.66
Биет бус хөрөнгийн хорогдуулга	15,812,500.00	0

Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2019 оны санхүүгийн тайланд
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Элэгдлийн зардлын дүн	150,951,731.13	157,857,223.66
Үл хөдлөх хөрөнгийн татвар	16,370,100.00	8,185,050.00
Газрын татвар	824,000.00	2,474,000.00
Тээврийн хэрэгслийн татвар	385,800.00	340,100.00
Хөрөнгийн даатгал	3,886,448.00	4,298,000.00
Татвар, даатгалын зардлын дүн	21,466,348.00	15,297,150.00
Хөдөлмөр хамгаалал	17,162,450.00	7,285,551.61
Дотоод сургалтын зардал	1,000,000.00	1,000,000.00
Сургалтын зардлын дүн	1,000,000.00	1,000,000.00
Дотоод томилолт	9,554,380.00	22,736,490.90
Албан томилолтын зардлын дүн	9,554,380.00	22,736,490.90
Харуул хамгаалалт	149,063.88	186,823.72
Цэвэрлэгээний зардал	2,289,642.69	2,683,665.42
Гал команд	1,081,500.00	4,545,445.46
Аудит баталгаажуулалтын зардал	228,000.00	120,000.00
Үйлдвэрлэлийн бусад зардал	300,000.05	700,000.01
Нийт ашиг (алдагдал)	-803,607,966.25	-915,143,752.26
Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	1,800,000.00	1,840,880.00
Аудит баталгаажуулалтын зардал	1,800,000.00	1,840,880.00
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-805,407,966.25	-916,984,632.26
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	386,920,030.49	796,835,345.52
Бусад үйл ажиллагааны бус орлого	778,868,750.80	852,440,432.81
Хүүгийн орлого	1,613,844.82	1,057,947.71
Бусад үйл ажиллагааны бус орлого	5,191,064.33	1,113,179.02
Санхүүжилт орлого	651,157,711.47	818,433,853.57
Систем хоорондын тооцоогоорх орлого	117,967,471.03	30,269,703.51
ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын олз	2,938,659.15	1,565,749.00
Бусад үйл ажиллагааны бус зардал	391,948,720.30	55,605,087.30
Шагнал	50,000.00	1,436,000.00
Тэтгэмж	1,530,000.00	1,603,000.00
Түлшний хөнгөлөлт	1,400,000.00	1,400,000.00
Банкны үйлчилгээний зардал	134,399.90	138,500.76
Спорт арга хэмжээний зардал	485,000.00	500,000.00
Эмнэлэг үйлчилгээний зардал	0	575,000.00
Баяр ёслолын зардал	0	900,000.00
Хүү торгуулийн зардал	0	19,799,019.25
Үйл ажиллагааны бус бусад зардал	4.33	0
Систем хоорондын тооцоогоорх зардал	56,660,073.22	29,253,567.28
ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын гарз	2,938,659.15	0
ҮХ данснаас хассаны гарз	328,750,583.70	0
ҮХ данснаас хассаны олз, гарзын зөрүү	-328,750,583.70	0
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	386,920,030.49	796,835,345.52
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-418,487,935.76	-120,149,286.74
Татварын дараах ашиг (алдагдал)	-418,487,935.76	-120,149,286.74
Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	-418,487,935.76	-120,149,286.74
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-418,487,935.76	-120,149,286.74

4.3 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(тогrog)

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
Мөнгөн орлогын дүн (+)	675,829,614.43	794,515,976.96
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	435,807.90	7,991,544.70
Даатгалын нөхвөр өөс хүлээн авсан мөнгө	1,589,868.00	0
Татаас, санхүүжилтийн орлого	661,950,000.00	780,100,000.00
ҮҮА-ны бусад мөнгөн орлого	11,853,938.53	6,424,432.26
Банк хоорондын гүйлгээ	2,370,000.00	13,891,500.00

Мөнгөн зарлагын дүн (-)	686,762,052.34	789,915,904.07
Ажиллагчдад төлсөн	363,679,836.52	402,846,093.69
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	76,383,613.23	64,756,750.11
Бараа материал худалдан авчгаад төлсөн	94,074,220.00	89,709,931.65
Ашиглалтын зардалд төлсөн	41,831,490.63	25,430,632.02
Түлш шатахуун, тээврийн хөлөг, сэлбэг хэрэгсэлд төлсөн	17,321,060.00	28,086,000.00
Татварын байгууллагад төлсөн	54,210,478.85	51,874,366.25
Даатгалын төлбөрт төлсөн	18,137,034.11	61,513,881.70
ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	21,124,319.00	65,698,248.65
Банк хоорондын гүйлгээ	2,370,000.00	13,891,500.00
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-10,932,437.91	4,600,072.89
Мөнгөн орлогын дүн (+)	406,008.02	0
Хүлээн авсан хүүний орлого	406,008.02	0
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	406,008.02	0
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-10,526,429.89	4,600,072.89
Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-10,526,429.89	4,600,072.89
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	11,238,869.16	712,439.27
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	712,439.27	5,312,512.16

4.4 Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(төгрөг)

Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0	0	0
2018 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,519,736,486.75	824,145,553.24	2,343,882,039.99
Залруулсан үлдэгдэл	1,519,736,486.75	824,145,553.24	2,343,882,039.99
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	-120,149,286.74	-120,149,286.74
2019 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,519,736,486.75	703,996,266.50	2,223,732,753.25

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР

Ж.ӨСӨХБАЯР

Огноо: 2020.03.12

Анхан шатанд хянасан:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЭНЯМ

Огноо: 2020.03.12

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

Огноо: 2020.03.12